


Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны
гарын авлагын 2 дугаар хавсралт



ЧАНАРЫН ЭРСДЭЛ БОЛОН БОЛОМЖИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЖУРАМ

БАЙГУУЛЛАГЫН НЭР	Монгол улсын их сургууль (МУИС)
БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ	Их сургуулийн гудамж – 1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
БАРИМТ БИЧГИЙН №	NUM/EOMS/PFC/007
ХУВИЛБАР №	01
БОЛОВСРУУЛСАН ОГНОО:	2025-10-01

НЭГ.ЗОРИЛГО

Энэхүү журам нь илрүүлсэн үйл явцуудын эрсдэл болон боломжыг баримтжуулах болон үүнтэй холбоотой байгууллагын үйл ажиллагааны эрсдлийг бууруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оршино.

ХОЁР.ХАМРАХ ХҮРЭЭ

МУИС-ийн боломжууд болон эрсдлүүдийг удирдах, тооцох, хэрэгжүүлэх болон засаж сайжруулахад ашиглана.

ГУРАВ.ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Дээд удирдлага, нэгжийн дарга нар өөрсдийн тодорхойлсон үйл явцад хариуцлага хүлээнэ.

ДӨРӨВ. ЖУРАМ

4.1. Байгууллага нь эрсдэл болон боломжуудыг доорх байдлаар харгалзан үзэж хянадаг. Үүнд:

- 4.1.1. Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо нь төлөвлөсөн үр дүндээ хүрч чадах эсэхийг баталгаажуулах;
- 4.1.2. Хүссэн үр нөлөөг сайжруулах;
- 4.1.3. Хүсээгүй нөлөөг бууруулах эсвэл сэргийлэх;
- 4.1.4. Сайжруулалт хийх;

4.2. Боловсролын Байгууллагын Менежментийн Тогтолцоог хэрэгжүүлэхээр тодорхойлсон бүх үйл явцын эрсдлийг үнэлнэ. Үйл явцын үйл ажиллагаанаас бий болж болзошгүй эрсдэлүүд болон хэвийн бус байдлыг хянан үзэх замаар эрсдэлийг тодорхойлдог. Эрсдэл болон боломжийн үнэлгээний явцад гадаад болон дотоод асуудлууд, сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлт болон процессийн үйл ажиллагааг харгалзан үздэг.

4.3. Эрсдэлийг хянана гэдэг нь эрсдэл үүсэх магадлалыг бууруулж хэрэв тухайн эрсдэл бий болсон тохиолдолд үүсэх нөлөөллийг бууруулахыг хэлнэ.

4.4. Эрсдэлийн үнэлгээг доорх байдлаар явуулна.

4.1.1 Эрсдэлийг олж илрүүлэх.

4.1.2 Эрсдэлийг аль үйл явцтай холбоотой байгааг тодорхойлох.

4.1.3 Тодорхойлсон эрсдэл болон түүний үр нөлөөг одоогийн хяналтандаа авах.

4.1.4 Эрсдэлийн индексийг хэр ноцтой байгаа (үр дагавар) болон хэр давтагдах магадлалтай байгааг доорх байдлаар тодорхойлно:

Ноцтой байдал (Үр дагавар)				
Маш бага	Бага зэрэг	Дунд	Өндөр	Маш өндөр (ноцтой)
1	2	3	4	5

Давтагдах магадлал				
Маш ховор	Ховор	Дунд зэрэг	Түгээмэл	Байнга
1	2	3	4	5

4.2. Эрсдэлий нөлөөг үнэлж, эрэмбэлнэ.

4.2.1. Эрсдэлийг үнэлсэний дараа тухайн эрсдэлийн нөлөөг эцсийн байдлаар үнэлгээний параметруудийг доорх байдлаар үржүүлэн тооцно.

Эрсдэлийн индекс = Ноцтой байдал (үр дагавар) * Давтамжийн индекс (давтагдах магадлал)

4.2.2. Эрсдэлийн ангиллыг доорх матрицийн дагуу эрэмбэлнэ:

Эрсдэлийн Матриц							
			Үр дагавар				
			Маш бага	Бага	Дунд зэрэг	Өндөр	Аюултай
			1	2	3	4	5
Давтамж	Маш бага	1	Бага (1)	Бага (2)	Бага (3)	Дунд (4)	Дунд (5)
	Бага	2	Бага (2)	Бага (4)	Дунд (6)	Дунд (8)	Дунд (10)
	Дунд	3	Бага (3)	Дунд (6)	Дунд (9)		
	Түгээмэл	4	Дунд (4)	Дунд (8)			
	Байнга	5	Дунд (5)	Дунд (10)			

4.5. Уг аргачлалын дагуу өндөр гэж үнэлэгдсэн бүх эрсдэлүүд дээр заавал эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

4.5.1. Арилгах, эрсдэлд тохирсон хяналтын дагуу бууруулах

4.5.2. Эрсдэлийг хуваалцах

4.5.3. Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх (Анхаарал болон хяналттай байж эрсдэлийг хэвээр хадгалах)

4.6. Зөвхөн өндөр эрсдэл дээр арга хэмжээ авах ёстой биш ба үйл явцын эзэн нь дунд болон бага эрсдэлүүдэд хэр чухал гэдгээс хамааран арга хэмжээ авах шаардлагатай.

Эрсдэлийн түвшин	Хэрэгжүүлэх төлөвлөгөө
	- Эрсдэлийг арилгах төлөвлөгөө гаргах замаар эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээ авах (заавал) - Эрсдэл болон удирдлагын тайланг тасралтгүй хянах
Дунд (4-10)	- Тохирох хяналтыг тогтмол хийх - Эрсдэлийг арилгах төлөвлөөний дагуу арга хэмжээ авах (заавал биш)
Бага (1-3)	- Шаардлагатай тохиолдолд эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авах (заавал биш) - Эрсдэлийг доод түвшинд байлгах, түүнд хяналт тавих

4.7. Сайжруулах боломжуудыг сайжруулах цар хүрээн дэх бүх үйл ажиллагаануудыг дүгнэснээр тодорхойлогдоно. Олж илрүүлсэн боломж нь эрсдэлийн шийдвэрлэх үйл ажиллагааны нэг хэсэг байж болно. Боломжууд нь шинэ дадлага, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, түншлэл байгуулах, шинэ технологи нэвтрүүлэх, үр ашгийг дээшлүүлэх болон зарцуулах ажилбар (хүчин чармайлтыг) багасгах, нөөцийг оновчтой ашиглах, зардлыг оновчлох болон байгууллага эсвэл үйлчлүүлэгчдийн хэрэгцээнүүдийг хангах бусад шаардлагатай боломжуудыг бий болгож чадна.

4.8. Эрсдэл болон боломжуудад авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдэд хяналт тавьж, үйл ажиллагааны үр нөлөөг тухайн хэлтэс нэгжийн дарга нар үнэлж, шаардлагатай тохиолдолд зохих арга хэмжээг авна. Энэхүү үйл ажиллагааны үр дүнг Менежментийн дүн шинжилгээний хурлаар хэлэлцэнэ.

4.9. Эрсдэлүүд болон боломжуудын бүртгэлүүдийг жилд нэгээс доошгүй удаа хянах шаардлагатай. Мөн түүнчлэн ямар нэгэн өөрчлөлт, үл нийцэл гэх мэтийг хэрэгжүүлэхээс өмнө МУИС-ийн Байгууллагын Менежментийн Тогтолцооны өөрчлөлт бүрийг хянаж бас сайжруулна.

ТАВ.ЛАВЛАГААНЫ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

5.1. ISO 21001:2018 стандартын шаардлага

1. ЗУРГАА. БҮРТГЭЛҮҮДИЙН ЖАГСААЛТ

Эрсдэлийн үнэлгээний бүртгэл

Эрсдэлийг арилгах төлөвлөгөө

Боломжуудын менежментийн төлөвлөгөө

ДОЛОО.ХЯНАЛТЫН ТҮҮХ

Хувилбар №	Өөрчлөлтийн дэлгэрэнгүй мэдээлэл	Хяналтын огноо	Өөрчлөлтийн шалтгаан	Өөрчлөлт оруулсан	Өөрчлөлтүүдийг зөвшөөрсөн
			---	---	---